



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/854

Ховд

Цэвэр усны станцын хамгаалалтын хашаа барих дэмжлэг
/"Шим-Ус" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар/-н
ажилд дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон төсвийн хөрөнгө оруулалтаар "Тахидаг хар" ХХК-ий хийж гүйцэтгэж буй Цэвэр усны станцын хамгаалалтын хашаа барих дэмжлэг /"Шим-ус" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /-н ажилд Ковид-19 цар тахлын улмаас хил гааль хаасантай холбоотой бараа материалын үнэ огцом өсч, үнийн хөөрөгдөл бий болсон тул тендерийн хэмнэгдсэн үнийн зөрүүг нэмэлтээр нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга

- Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд:

Н.Ганзориг

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

М.Нансалмаа

- "Шим-ус" орон нутгийн өмчит аж ахуйн
тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий
инженер

Ц.Отгонцэцэг

- "Тахидаг хар" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж

- Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын мэргэжилтэн

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН